

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

НЭГ. Ерөнхий заалт

1.1 Энэхүү үйлчилгээний нөхцөлийг цахим орчинд зар оруулах, өөрийн бүтээсэн файл, загвар дизайн, худалдан борлуулах систем болох www.kok.mn (“kok” эсхүл “Вебсайт” гэх)-д бүртгүүлсэн хувь хүн, хуулийн этгээд (“Контент бүтээгч”) дагаж мөрдөнө.

1.2 Контент бүтээгч энэхүү үйлчилгээний нөхцөлтэй бүрэн танилцаж, хүлээн зөвшөөрсөн тохиолдолд Вебсайт дахь “Зөвшөөрч байна” гэсэн сонголтыг сонгоно. Ийнхүү “Зөвшөөрч байна” сонголтыг хийснээр энэхүү үйлчилгээний нөхцөл хүчин төгөлдөр хэрэгжинэ. Kok нь Контент бүтээгчид урьдчилан мэдэгдэл, анхааруулга илгээхгүйгээр энэхүү үйлчилгээний нөхцөлд дангаар өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд Контент бүтээгч Вебсайтыг үргэлжлүүлэн ашигласнаар тухайн өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

1.3 Энэхүү үйлчилгээний нөхцөлийн хэрэгжилтэд Kok болон тус сайтын хэрэглэгч, Контент бүтээгчид, сайтын хэрэглэгчид хамтран хяналт тавина.

1.4 Контент бүтээгч нь өөрийн байршуулсан зар, файльтай холбоотой бүхий л хариуцлагыг хүлээнэ.

1.5 www.kok.mn нь нийтлэгдсэн зар, контент-той холбоотой аливаа гомдол гарсан тохиолдолд устгах эрхтэй.

ХОЁР. Вэбсайт түүний үйл ажиллагаа

2.1 Вэбсайт нь байнгын ажиллагаатай байж, тогтмол шинэчлэгдэн Контент бүтээгчийн шинэлэг загвар, бүтээлүүдийг Вебсайтаар дамжуулан хэрэглэгчдэд хүргэнэ.

2.2 Вэбсайтын үйлчилгээнд зориулан хэрэглэгдэж байгаа програм хангамж, лого, тэмдэг, дизайн, шийдэл нь Kok-ын өмч бөгөөд Kok-ын зөвшөөрөлгүйгээр аливаа хэлбэрээр эзэмших, ашиглахыг хориглоно.

2.3 Вебсайтад байршсан бүх төрлийн файл загвар дизайн бүр зохиогчийн эрхээр хамгаалагдсан бүтээл эсхүл зохиогчийн өөрийн бүтээлээр баталгаажсан тул тэдгээрийг хуулах, олшруулах, дуурайх, дамлан борлуулах болон өөр бусад байдлаар зөвшөөрөлгүй ашиглахыг хатуу хориглоно.

2.4 Админ оператор /80025060/ ажлын өдрүүдэд 09:00-20:00, амралтын өдрүүдэд 10:00-20:00 цагийн хооронд ажиллана.

2.5. Kok нь вебсайтын шинэчлэл, үйлчилгээний сайжруулалт хийх, техник, технологи, програм хангамжийн өөрчлөлт хийх болон эдгээртэй адилтгах бусад шалтгаанаар Вебсайтын хэлбэр, загвар, агуулга, үзүүлж буй үйлчилгээ зэргийг бүхэлд нь буюу хэсэгчлэн аливаа мэдэгдэл, анхааруулгагүйгээр өөрчлөх, шинэчлэх эрхтэй.

2.6. Kok нь үзүүлж буй үйлчилгээгээ түр буюу бүр мөсөн зогсоох эрхтэй.

ГУРАВ. Вэбсайтын гишүүнчлэл

3.1 Контент бүтээгч нь Вебсайтад өөрийн контентыг оруулах тохиолдолд гишүүнчлэлийн мэдээллийг бөглөн Кок-д бүртгүүлэн нэвтрэх эрх авна. Нэг нэвтрэх эрхийг хэд хэдэн этгээд давхар ашиглахыг хориглоно.

3.2 Контент бүтээгч нь гишүүнчлэлийн мэдээллийг үнэн зөв, алдаагүй бөглөх үүрэгтэй. Гишүүнчлэлийн мэдээллийг үнэн зөв, алдаагүй бөглөөгүйгээс бүртгэл баталгаажихгүй байх, төлбөр тооцооны саатал үүсэх болон эдгээрээр хязгаарлагдахгүй бусад нөхцөл байдал үүссэнтэй холбогдон үүсэх аливаа хариуцлагыг Контент бүтээгч хариуцна.

3.3 Вэб сайтын гишүүн болсон хэрэглэгч хувийн мэдээллийн хэсэгтэй байна. Үүнд:

- Гишүүний хувийн мэдээлэл
- К поинт онлайн хэтэвч
- Контент удирдах хэсэг
- Борлуулалтын түүх

ДӨРӨВ. Кок-д бүтээл байршуулах, нийтлэх

4.1 Вебсайтад бүртгүүлсэн Контент бүтээгч нь бүх төрлийн загвар файл, зураг, элемент, видео, фонт зэрэг өөрийн бүтээлийг Вэбсайтад байршуулах, нийтлэх эрхтэй.

4.2 Вебсайтад байршуулах, нийтлэх бүтээл нь агуулга болон хэлбэрийн хувьд нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс зүйн хэм хэмжээнд харш бус, хууль бус, зүй бус зүйлд уриалсан шинжгүй, бусдыг өдөөн хатгасан, сүрдүүлсэн, бусдын нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон шинжгүй, зохиогчийн эрхийн аливаа зөрчилгүй бүтээл байна.

4.3 Кок нь Контент бүтээгчийн байршуулсан, нийтэлсэн бүтээл нь эрх зүйн хэм хэмжээ, Кок-ын бодлогод харш, зохиогчийн эрхийн зөрчилтэй байгаа тохиолдолд Вебсайтаас устгах эрхтэй.

4.4 Контент бүтээгч нь Вебсайтад байршуулсан бүтээлээ устгах, өөрчлөх эрхтэй.

4.5 Контент бүтээгчийн оруулсан загвар дизайн нь нийтлэгдэж хэрэглэгчид хүрснээр зохиогчийн эрхийн зөрчлийн гомдол ирсэн тохиолдолд тус загварыг хаах ба тус загвараас олсон орлогыг www.kok.mn хэрэглэгчийн гомдол барагдуулахад зарцуулна.

ТАВ. Төлбөр тооцоо

5.1 Контент бүтээгчийн бүтээл дараах өөрийн үнэлэмжээс хамаарч бусад бүтээлүүдээс харилцан ажилгүй үнэлгээтэй байж болох бөгөөд энэхүү үнэлгээг зохиогч өөрөө тодорхойлж оруулна. Үнэлгээний үнэн бодит байдлыг сайтын зүгээс хянах бөгөөд хэт өндөр эсвэл хэт доогуур үнэлсэн гэж үзвэл уг нийтлэлийг хасах болно.

5.2 Үйлчилгээний нөхцөлийн заасан үнийн дүнд өөрчлөлт оруулах хүсэлтэй бол Контент бүтээгч koklikeshare@gmail.com и-мэйл хаягаар саналаа хүргэж загвараа үнэлүүлэх боломжтой.

5.3 Контент бүтээгчийн оруулсан загварын борлуулагдсан орлогоос Контент бүтээгчид ногдох хэмжээг Хавсралт 1-ийн дагуу тодорхойлно.

5.4 Гэрээт контент бүтээгчийн оруулсан загвар борлуулагдсан орлогоос Контент бүтээгчид ногдох хэмжээг Хавсралт 2-ийн дагуу тодорхойлно.

5.5 Тус веб сайтад нийтлэгдсэн контент загвар тус бүр дизайнерайн зохиогчийн эрхээр хамгаалагдсан бөгөөд энэ сайтаас бусад газар борлуулахыг хатуу хориглоно.

5.6 Контент бүтээгчийн өөрт ногдох орлогын хэмжээ нь 5,000 төгрөгөөс дээш гарсан тохиолдолд хүсэлт гарган өөрийн дансанд шилжүүлэн авах боломжтой.

5.7 Дизайнер онлайн хэтэвчээ ашиглан бусад загвар, элементүүдийг худалдан авах боломжтой ба тэдгээрийг буцааж зарах боломжгүй.

ЗУРГАА. Бусад

6.1 Сайтын үйлчилгээ, загвар, худалдан авалт, төлбөрийн талаар ямар нэгэн асууж тодруулах зүйл, санал хүсэлт гарвал операторын koklikeshare@gmail.com и-мэйл хаяг руу болон kok.mn фейсбүүк хуудсанд холбогдон лавлагаа авч болно. Эсвэл 80025060 дугаарт холбогдон мэдээлэл авч болно.

6.2 Хэрэглэгчийн зүгээс оюуны өмчийн талаар гомдол санал хүсэлт гаргасан тохиолдолд www.kok.mn сайны зүгээс Контент бүтээгчтэй холбогдож асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу эцэслэн шийдвэрлэж хэрэглэгчид хариу и-мэйл хүргэх болно.

6.3 Контент бүтээгч энэхүү нөхцөлд заасан үүрэг болон хориглосон зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд Кок нэг талын санаачилгаар Контент бүтээгчийн нэвтрэх эрхийг хасч, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй.

6.4. Контент бүтээгчийн байршуулсан бүтээл нь Кок-ын байр суурийг илтгэхгүй бөгөөд байршуулсан бүтээлтэй холбоотой аливаа хариуцлагаа Кок-оос ангид байна.

6.5 Талуудын хооронд аливаа маргаан гарсан тохиолдолд харилцан зөвшилцөж шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд ийнхүү шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын хуулийн дагуу шийдвэрлүүлнэ.

Хавсралт 1

Энгийн хэрэглэгч буюу контент бүтээгч нь өөрийн байршуулсан файлын орлогын 20% ийг орлого хуваах зарчимаар авна. Ингэхдээ өөрийн файлын орлогоо 5000 төгрөгөөс дээш гарсан тохиолдолд орлого авах хүсэлтийг өөрийн бүртгэлтэй мэйл хаягнаас илгээнэ.

Хавсралт 2

Гэрээний дагуу контент нийтлэгч нь хамтран ажиллах гэрээний хүрээнд тухайн контентын орлогын хувийг тохиролцох бөгөөд орлого татан авалтыг сард нэг удаа хийнэ. Мөн тухайн нийтлэгчийн хувьд гишүүнчлэл нь багцын хураамжтай байна.